



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/131

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хужирт сумын Сэмжид рашаан сувилалд амарч байсан иргэдийн дундаас Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын батлагдсан тохиолдол илэрсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг авч, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдын төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дээрх сумдад эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, өвс, малын тэжээл шатахууны тээврээс бусад орох, гарах сум, баг хоорондох хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цаг хүртэл хориглосугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, хүнсний худалдаа, үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаанаас бусад нийтийн тээвэр, такси үйлчилгээ, үсчин, авто засварын газар, усан бассейн, фитнес, боловсролын байгууллага, барааны зах, халуун ус, үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, сүм хийд, кино театр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газар, зочид буудал, баар, ресторан, зоогийн газруудын үйл ажиллагааг түр зогсоосугай.

4.Хүнсний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, уст цэгийн ажиллах цагийн хуваарийг 09:00-20:00 цаг хүртэл тогтоож, энэ хугацаанд нэг айл өрхөөс нэг иргэнийг эрүүл мэндийн үйлчилгээ, уст цэг, хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), дээрх сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Хүнсний худалдаа, эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагуудыг эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрмийг чанд сахиж ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгүүлж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д тус тус даалгасугай.

011100284

2.

6.Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон Эрүүл мэндийн байгууллагаас бусад байгууллагын албан хаагчдын 10 хүртэл хувийг ажиллуулах, бусад ажилтан албан хаагч нарыг цахимаар ажиллуулах нөхцөл боломжоор хангаж ажиллуулахыг газар, хэлтэс, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад даалгасугай.

7.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын цаг үеийн нөхцөл байдлын талаар ард иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлж, хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөрөгдөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагын албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлэн зөрчлийг арилгаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (Д.Цэдэнбалжир)-т тус тус даалгасугай.

8.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тухайн сумдад 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 хүртэл хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ